

ДОРНОД АЙМАГ
БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 1152

Чойбалсан

Үндсэн хөрөнгө орлогод авах тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 заалт, Төрийн өмчийн хорооны "Төрийн өмчийн хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг "ТИКА"-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд дүрс оношилгоо, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасагт нийлүүлэгдэж буй 259 014 000 төгрөг (хоёр зуун тавин есөн сая арван дөрвөн мянга)-ийн үнэ бүхий ходоод гэдэсний замын уян дурангийн иж бүрдэл, дурангийн угаалга, ариутгалын төхөөрөмж, унтуулгын аппарат зэрэг тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бүртгэхийг Нягтлан бодогч О.Солонгод үүрэг болгосугай.

2. Тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, холбогдох баримтуудтай танилцан шалгаж, бүртгэн авч холбогдох тасаг нэгжид хуваарилах ажлыг зохион байгуулахыг Өмч хамгаалах комиссын дарга Ж.Энхчимэг, гишүүдэд даалгасугай.

3. Хүлээн авсан тоног төхөөрөмжийг эзэмших, зөв зохистой ашиглах, үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд анхаарч ажиллахыг тасгийн эрхлэгч /С.Юндэндорж, Х.Урантуяа/ нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанарын албаны дарга Д.Ганхүрэлд хариуцуулсугай.

ЗАХИРАЛ  Д.ДОЛЖИН

